

## **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл**

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2005 онд баримтлах үндсэн чиглэл нь санхүүгийн зуучлалын хэмжээ болон өрсөлдөөн нэмэгдэж буй орчинд төгрөгийн болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хадгалахад чиглэгдэнэ.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанк дараахь үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг жилийн 5 хувиас хэтрүүлэхгүй байхыг зорино.
- Дунд болон урт хугацааны санхүүгийн хэлцлүүд буюу орон сууц, газар болон бусад үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан зээл олголтын тогтолцоог сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Төгрөгийн форвард зах бий болгох дэд бүтэц, бизнес эрхлэгчдийн санаачлагыг дэмжинэ.
- Гадаад, дотоод зах зээлээс хөрөнгө оруулалт, хямдралттай санхүүжилтын эх үүсвэр дайчлан эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.
- Мөнгөний бодлогын холбогдолтой судалгааг эрчимжүүлэн Монгол улсын эдийн засгийг загварчлах ажлыг Засгийн газартай хамтран эхлүүлнэ.
- Банк, санхүүгийн салбарын хөгжлийн тогтвортой байдлыг хадгалах, эдийн засаг дахь зээл, санхүүгийн орчныг таатай болгох зорилгоор банкны барьцаа хөрөнгийг захиран зарцуулахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтуудыг боловсронгуй болгох зэргээр санхүүгийн харилцаанд оролцогчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх чиг баримтална.
- Банк, санхүүгийн зах зээл дээрх шударга өрсөлдөөнийг дэмжих, банкны үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, активын багцын чанарыг дээшлүүлэх
- Банк бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаагаа зохицуулах, банк бус санхүүгийн зах зээлийн талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлчлүүлэгчдийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах үүрэгтэй Санхүүгийн зохицуулах хороог байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх арга хэмжээ авна.
- Хяналт шалгалтын үйл ажиллагааг эдийн засгийн ерөнхий төлөв байдалтай

уялдуулах чиглэлийг баримтална.

- Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийн үйл ажиллагааг жигдрүүлж, хөгжлийг нь улам боловсронгуй болгох талаар нэгдсэн зохицуулалт хийнэ.
- Үйлдвэрлэлийг дэмжиж ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор гадаадаас хямд эх үүсвэртэй фонд /зээл/ дайчилж, арилжааны банкуудаар дамжуулан зээлдүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

МОНГОЛБАНК